



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/166

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.1.1, 8.2.3, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулж, хяналт шалгалт хийлгэх тухай” 05/5940 тоот албан бичигт тусгагдсан асуудлаар хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулж, тогтоогдсон нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагыг мэдээллээр хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Болд (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга)

Гишүүдэд:

Ш.Дамдиндорж (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

А.Догсмаа (Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны ахлах аудитор)

Д.Пүрэвсүрэн (Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны аудитор, улсын байцаагч)


Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Х.Цэнд-Аюуш (Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, дүгнэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн дотор хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрэднэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 0010693